



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/271

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/206 дугаар захирамжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр явагдах газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

3.Нямбаяр (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд Ө.Дугарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээллийн сан, техник, программ хангамж хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:


Б.Батмөрөн (Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (3.Нямбаяр)-д даалгасугай.

3.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай ажиллахыг анхааруулсугай.

4.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010855 Захирамж2024